

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД
Ц.САНДАГ-ОЧИР

2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
С.АМАРСАЙХАН

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан.

Монгол Улс 1992 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцод нэгдэн орж, энэхүү конвенцыг хэрэгжүүлэх Парисын хэлэлцээрийг 2016 онд Улсын Их Хурлаар соёрхон баталж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвараа сайжруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулах үүрэг хүлээсэн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.4-т “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.” гэсэн зорилт дэвшүүлж, 2021-2030 (I үе шат) онд эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна, 2031-2040 (II үе шат) онд уур амьсгалын өөрчлөлтийн шинэ хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн үндэсний ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ, 2041-2050 (III үе шат) онд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн зөрүүг тэглэнэ гэж тус тус тусгасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилтийн хүрээнд хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна, уур амьсгалын өөрчлөлтийн

олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд “4.1.Анхдагч экосистемийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулна...” гэж тус тус заасныг үндэслэл болгон хуулийн төслийг боловсруулна.

1.2.Практик шаардлага

Монгол Улс газар зүйн байршил, цаг уурын онцлог, нүүдлийн соёл зэргээс хамааран нийгэм, эдийн засгийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий, эрсдэлтэй орны тоонд ордог.

Манай орны жилийн агаарын температур сүүлийн 85 жилд дунджаар 2.5°C^1 хэмээр, зарим нутагт $3-3.5^{\circ}\text{C}$ -ээр дулаарч, хуурайших хандлага давамгайлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол орны хэмжээнд сүүлийн 10 жилд нийт нуурын тоо 132-оор буурч ширгэн, нуурын усан гадаргын талбай 50.3^2 км²-аар багассан бол мөсөн голын талбай сүүлийн 80 жилд $40-47^3$ хувиар багасаж, нийт нутаг дэвсгэрийн 76.8^4 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн байна. Манай улсад 1990-2023 оны хооронд тохиолдсон ус, цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 60 удаа байсан бол сүүлийн 10 жилд 98^5 болж нэмэгдэж, жил бүр ойролцоогоор 50-70 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч хохирлын хэмжээ 10-14 дахин нэмэгдсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс 2050 оны үед бий болох зарим өөрчлөлтийн таамаглалыг авч үзвэл улирлын агаарын температур $2.0-2.3^{\circ}\text{C}$ хүртэл, ган, зудын давтагдал 5-45 хувиар, агаар мандлын гаралтай аюултай үзэгдлийн давтагдал 23-60 хувиар тус тус нэмэгдэх⁶, Монгол орны цэвдэгт хөрсний талбай 33-61.23 хувиар буурах чиг хандлагатай. Энэ нь манай улсын хувьд байгалийн гамшгаас үүдсэн нийгэм, эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэй ган гачиг, зуд турхнаас шалтгаалан хөдөө орон нутгийн иргэдийн хот суурин газар руу шилжих шилжилт хөдөлгөөн эрчимжиж, төвлөрлийг бий болгосноор Улаанбаатар хотын агаарын бохирдол, автозамын түгжрэл, төлөвлөлтгүй газар ашиглалт, ажилгүйдэл ядуурал нэмэгдэх, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж буурах зэргээр нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан болж байна.

Монгол Улсын хүлэмжийн хийн нийт ялгарал 1990 оноос хойш 82.1 хувиар нэмэгдсэн нь дээрх хүн амын төвлөрөл нягтшил, үйлдвэрлэл хэрэглээ, малын тоо толгойн өсөлттэй холбоотой бөгөөд нийт хүлэмжийн хийн ялгарлын 51.1 хувийг

¹ Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2021-2023 он

² Монгол орны нууруудын дүрсзүйн үзүүлэлтүүдийг тодорхойлох”, УЦУОСМХ, Б.Эрдэнэбаяр, 2023 он

³ Мөстөл, Мөсөн голын масс балансын судалгаа”, УЦУОСМХ, Х.Пүрэвдагва, 2023 он

⁴ Монгол орчны цөлжилтийн атлас, УЦУОСМХ, 2020 он

⁵ Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2021-2023 он

⁶ НҮБ/УАӨСК-ын хэрэгжилтийн үндэсий 4 дүгээр тайлан-илтгэл, 2024 он

хөдөө аж ахуйн салбар, 44.7 хувийг эрчим хүчний салбар, үлдсэн хувийг аж үйлдвэрийн салбар болон хог хаягдлаас үүсч байна.

Бага нүүрстөрөгч бүхий цэвэр үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эрхзүйн орчин дутмаг, салбар дундын зохицуулалт тодорхойгүй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлэх цогц судалгаа, өгөгдөл, мэдээллийн сан хангалтгүй байгаа нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зах зээлд суурилсан арга хэрэгслийг нэвтрүүлэх олон улсын туршлагыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал болж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг салбараар болон орон нутгийн хэмжээнд хийж, дасан зохицох арга хэмжээг төлөвлөх, шаардагдах санхүүжилтийн олон талын эх үүсвэрийг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учирсан болон учирч болзошгүй эрсдэл, гарз, хохирлыг тооцоолох, хүлэмжийн хийн ялгарлын тооллого хийх, хянах, тайланг батлах, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажил үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, салбар дундын уялдаа холбоог зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эдгээр хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ, шаардлагад үндэслэн тус хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зорилго нь хүлэмжийн хийг тэг ялгаралд хүргэх, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох болон даван туулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн карбон зах зээлийг бүрдүүлэх, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүртгэл, мэдээллийн сан, тайлагналын нэгдсэн тогтолцоог бий болгоход оршино.

Хуулийн төсөл нь дараах бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд баримтлах зарчим болон хуульд хэрэглэсэн нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн байгууллагууд болох Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага болон үндэсний зохицуулагч байгууллагын эрх, үүргийг тусгана.

Гуравдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, хүлэмжийн хийн үндэсний тооллого, харгалзах тохируулга, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, шинжилгээ, мэдээллийн суурь тогтолцоотой холбоотой харилцааг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө, дасан зохицох арга хэмжээ, хохирлын үнэлгээ болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилттэй холбоотой харилцааг тусгана.

Зургаадугаар бүлэгт ногоон санхүүжилтийн эх үүсвэр, санхүүгийн хэрэгсэл, шалгуур, нийцэл, ил тод байдал, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой харилцааг тусгана.

Долдугаар бүлэгт карбон зах зээлийн хэлбэр, карбон кредитийг үүсгэх, баталгаажуулах, бүртгэх, шилжүүлэхтэй холбоотой харилцааг тусгана.

Наймдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн сан, мэдээллийн тогтолцоо, ил тод байдал, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулна.

Есдүгээр бүлэгт хориглох үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдэж хүлэмжийн хийн тооллого, тооцоолол, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээний нэгдсэн зохицуулалт бий болно.

2. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж, судалгаанд үндэслэсэн нэгдсэн бодлого төлөвлөлтөөр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

3. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой Монгол Улсын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд олон улсын болон төр, хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын механизмыг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

4. Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, мэдээлэлд суурилсан бодлого, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх салбар хоорондын зохицуулалт боловсронгуй болж, Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах эрсдэлийг удирдах, байгалийн гамшгаас сэргийлэхтэй холбоотой салбар дундын уялдаа холбоо

сайжруулах, Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсон улсын хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ.

5. Карбон зах зээлийн кредит баталгаажуулах, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлснээр карбон кредитийг эдийн засгийн эргэлтэд оруулж улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

6. Түүнчлэн, уур амьсгалын санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад шаардлагатай санхүүжилтийн найдвартай, тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болно.

7. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хамгаалах бодлого, арга хэмжээний хэрэгжилт системтэй болно.

8. Хүлэмжийн хийн ялгарлын тэнцлийг хангах зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, технологийн шинэчлэл, инновацыг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Агаарын тухай, Авто замын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Барилгын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Олон улсын гэрээний тухай, Статистикийн тухай, Тариалангийн тухай, Хот байгуулалтын тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.